



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 4/166

Арвайхээр

Дүрэм батлах тухай

МУ-ын Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 29-ын 1.5 "б" заалт, Засгийн газрын 2015 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоолын "1" дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын "Үлгэрчилсэн дүрэм, чиглэл батлах тухай" 2015 оны а/76 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх "Байгаль орчин, аялал жуулчлалын газар"-ын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Г.Баясгалан/-д дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс /Ж.Самданжигмэд/-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/15 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТОГТОХСҮРЭН



02 0334  
D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2015 оны 04  
дугаар сарын 14-ны өдрийн 16/дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ**

***Нэг. Нийтийн үндэслэл***

1.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар /цаашид “газар” гэнэ/-ын бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.


1.2 Газар нь үйл ажиллагаандaa Байгаль орчны багц хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актууд, төрөөс байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан бодлогын баримт бичгүүд, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймгийн ИТХурал, Засаг даргын гаргасан шийдвэрүүдийг мөрдлөг болгоно.

1.3 Газар нь аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сум орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн бие даасан агентлаг мөн.

1.4 Газрын үндсэн зорилго нь: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд оршино.

1.5 Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагуудаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Онги-Таац голын сав газрын захиргаа, Ус цаг уур орчны шинжилгээний албыг мэргэжил арга зүй, дэмжлэг, нэгдсэн бодлого зохицуултаар хангаж ажиллах;

1.6 Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалтай



холбогдолтой мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

1.7 Газар нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх, булэг, хамтлаг, нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх, хувийн хэвшлийнхний байгаль орчноо хамгаалах сайн дурын идэвхи санаачлагыг өрнүүлэх, байгаль орчинд ээлтэй техник технологи, сайн туршлагыг нэвтрүүлэх, үнэлэх, урамшуулах ажлыг зохион байгуулна.

1.8 Газар нь аймгийн Байгаль орчны зөвлөлтэй хамтран сумын байгаль орчин, тогтвортой хөгжлийн тасгийг мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангаж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

#### **Хоёр. Газрын удирдлага, бүтэц**

2.1 Газар нь үүрэг, зорилгоо хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоог хангах асуудлаар газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиллуулах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын ахиргааны дарга, Онги-Таац голын сав газрын захиргааны дарга, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Ойн нэгжийн дарга, Байгаль орчны салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц-дотоод ажил хариуцсан мэргэжилтнийг тус тус оруулна. Зөвлөлийг газрын дарга удирдаж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг өөрийн тушаалаар батална.

2.2 Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.2.1 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.2.2 Газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтыг батлуулах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах;

2.2.3 Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх;


2.2.4 Батлагдсан төсвийг захиран зарцуулах;

2.2.5 Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах;

2.2.6 Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

2.2.7 Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах;

2.2.8 Газрын бүрэлдэхүүнд Ойн нэгж ажиллуулах, Сум дундын Ойн ангийг харьяалах;



2.2.9 Сумдад ажиллах байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

**Гурав. Газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**


3.1 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр батлагдсан Ерөнхийлөгчийн зарлиг, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын баримт бичгүүд, холбогдох эрх зүйн акт, үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн үндсэн чиглэлд байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах;

3.2 Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих;

3.3 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хариуцан зохион байгуулах;

3.4 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн болон усны нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангуулах, байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах;

3.5 “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр эхлэх төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаарх тайланг жил бүр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх;



3.6 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.7 Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх;

3.8 Аймгийн байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жилд нэг удаа гаргах.

3.9 Байгаль орчныг хамгаалах ажилд иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хангах ажлыг зохион байгуулах;

3.10 Байгаль хамгаалагчдыг сонгон шалгаруулах, мэргэжлийн удирдлагаар тогтмол хангаж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шагнаж урамшуулах, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжпэг үзүүлэх;

3.11 Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, улсын захиалга, даалгаварт ажлын хэрэгжилтийг хангуулах;

3.12 Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, халгүй хаягдалгүй, цэвэр технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх;

3.13 Орон нутгийн хэмжээнд ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд үнэлгээ хийх, ан агуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;

3.14 Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөц, дурсгалт газрын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг хариуцах;

3.15 Аймгийн ойн сангийн ой зохион байгуулалтыг явуулж, өөрчлөлтийг тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн



дэмжлэг туслалцаа үзүүлэх, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

3.16 Бүс нутгийн байгаль орчинд зохицсон, зохих материаллаг бааз бүхий модлог ургамлын үргүүлгийн газар байгуулахад дэмжлэг үзүүлэх, тарьц, суулгац ургуулах, мод сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэж орон нутгийн хэрэгцээг хангах;

3.17 Мод бэлтгэх талбайг тусгаарлах, мод бэлтгэлийн ажилд технологийн хяналт тавьж, мод бэлтгэсэн талбайг хүлээн авч дүгнэлт гаргах, мод, модон түүхий эд бэлтгэдэг мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, техник, технологийн өндөр түвшинд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах, зах зээлд чанар сайтай модон материал нийлүүлэх явдлыг дэмжих замаар хууль бусаар мод бэлтгэх явдлыг таслан зогсоох, орон нутгийн модны хэрэгцээг хангах ажилтай уялдуулан зохион байгуулах;

3.18 Ховор, нэн ховор амьтныг нутагшуулах, ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулах;


3.19 Усны нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, хаврын шар ус, борооны усыг хуримтлуулж усан сан, хөв цөөрөм байгуулах зэрэг арга хэмжээг нутаг орны байдалд тохируулан сав газрын захиргаа болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

3.20 Гадаргын болон газрын доорх ус авах барилга байгууламж, гүний худгуудын ашиглалтад хяналт тавих, тоолууржуулах, эзэн хариуцагчтай болгох ажлыг хариуцан, Сав газрын болон усны мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

3.21 Агаарын бохирдол, хог хаягдал, химиин бодисын менежмент, био аюулгүй байдлын асуудлаар бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, ус, хөрсийг бохирдоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд Ус, цаг уур, орчны шинжилгээний албыг татан оролцуулах;

3.22 Ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг хамгаалах, түүнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

3.23 “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд хургуулж байх, статистик мэдээлэл нэгтгэж гаргах;



3.24 Байгалийн нөөц баялаг болон газар зүйн мэдээлэлд суурилсан мэдээллийн санг хариуцаж холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээ, мэдээллээр үйлчлэх;

3.25 Байгаль орчин, ногоон хөгжлийн холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах;

3.26 Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах;

3.27 Усны нөөц, түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж усны мэдээллийн сан байгуулах, гадаргын усны тооллого хийх, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандын тоо, мэдээллийг гаргах, холбогдох дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

3.28 Иргэдийн ногоон хөгжлийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, аж ахуйн нэгж байгууллагын байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх;

3.29 Байгаль орчинд ээлтэй дэвшилтээ технологи бүхий үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг хөгжүүлж, нөөцийн дахин ашиглалт, дахин боловсруулалтыг дэмжих;

3.30 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн идэвх оролцоог дэмжиж, хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх;

3.31 Аймгийн хэмжээнд шинээр батлагдан гарах бодлогын баримт бичиг, шийдвэрт ногоон хөгжлийн үзэл баримтлалыг тусгах;

3.32 Аялал жуулчлалын салбарыг тухайн орон нутагт хөгжүүлэх төлөвлөлт, менежмент, бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг хангах;

3.33. Аялал жуулчлалыг бүсчилэн хөгжүүлж, дэд бүтцийг бүрдүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;

3.34 Аялал жуулчлалын салбарын нөөцийн судалгаа хийх, мэдээллийн бааз бий болгох статистик мэдээ гаргах;

3.35. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, жуулчны бааз бусад үйлчилгээний газар, туроператор аж ахуй нэгжүүдийг мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах;

#### **Дөрөв. Газрын санхүүжилт**

4.1 Газрын санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд заасан тухайн жилд гүйцэтгэх арга хэмжээнд зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгө;

4.1.2 “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай” хуулиар зохицуулагдах хөрөнгийн тодорхой хэсэг;

4.1.3 Олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, орон нутгийг хөгжүүлэх сан болон бусад эх үүсвэр;

4.1.4 Газар нь өөрийн өмч хөрөнгөтэй байж, түүнийгээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу захиран зарцуулна.

-оОо-

Аймгийн Засаг даргын 2015 оны 01  
дугаар сарын 24..ны өдрийн 06 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ

- Аймгийн засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Нягтлан бодогч-1
- Ойн нэгж-1
- Мэргэжилтэн 6
- Архив-бичиг хэргийн эрхлэгч
- Сумдын байгаль хамгаалагчид 18
- Жолооч, нярав

-оOo-

